



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2024/143/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn Булган
аймаг

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ

Утас: **7034-2580**

Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: **7034-2716**

Цахим хаяг: : enkhtsoodolj@audit.gov.mn

ЦЭСБ аудит ХХК-ийн захирал: Ч.Цэрэннадмид

Утас: **9511-2689**

Цахим хаяг: tseb.audit@gmail.com

Аудитор Ш.Ганчимэг

Утас: **99377360**

Цахим хаяг: shagdarganchimeg44@jmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13-14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	14-16
4. Аудитын тайлан.....	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17-18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. Аудитын илрүүлэлт	19-20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НББ	Нягтлан бодох бүртгэл
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БЕГ	Боловсролын ерөнхий газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Үлдэгдэл	Үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	121,623,516.87	294,341,628.12
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	25,847,320.33	188,238,834.66
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	25,847,320.33	188,238,834.66
3121	Төгрөг	25,847,320.33	188,238,834.66
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	25,847,320.33	188,238,834.66
33	АВЛАГА		12,603.78
331	Ажиллагчидтай холбогдсон авлага		12,603.78
35	БАРАА МАТЕРИАЛ	95,776,196.54	106,090,189.68
353	Бэлэн бүтээгдэхүүн	3,952,920.00	6,085,360.00
354	Хангамжийн материал	91,823,276.54	100,004,829.68
3546	Хүнсний материал	10,666,100.00	6,831,800.00
3547	Бусад хангамжийн материал	81,157,176.54	93,173,029.68
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,363,314,204.80	1,478,628,969.66
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,363,314,204.80	1,478,628,969.66
392	Биет хөрөнгө	1,293,795,204.80	1,409,278,719.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,318,633,548.70	1,318,633,548.70
39202	Хуримтлагдсан элэгдэл	-168,848,048.12	-189,185,015.54
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	118,843,404.30	262,847,303.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-41,067,380.72	-44,594,229.82
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	81,315,729.43	74,409,150.93
39208	Хуримтлагдсан элэгдэл	-28,948,629.81	-25,988,554.75
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,678,337.50	21,678,337.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	-10,707,294.72	-12,320,833.20
39217	Ном	2,895,538.24	3,799,012.24
393	Биет бус хөрөнгө	69,519,000.00	69,350,250.00
39301	Програм хангамж	2,587,798.00	2,587,798.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,912,798.00	-2,081,548.00
39303	Бусад биет бус хөрөнгө	68,844,000.00	68,844,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,484,937,721.67	1,772,970,597.78
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		69,997,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		69,997,000.00
413	Өглөг		69,997,000.00
4136	Бусад өглөг		69,997,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг		69,997,000.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,484,937,721.67	1,702,973,597.78
51	Засгийн газрын хувь оролцоо	1,484,937,721.67	1,702,973,597.78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	666,081,812.58	666,081,812.58
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	-478,939,793.91	(260,903,917.80)
5121	Өмнөх үеийн үр дүн	-478,939,793.91	(478,939,793.91)
5122	Тайлант үеийн үр дүн		218,035,876.11
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,297,795,703.00	1,297,795,703.00

VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,484,937,721.67	1,772,970,597.78
----	--	------------------	------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,552,708,145.30	1,863,490,275.14
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	53,424,773.30	67,026,897.14
120	Нийтлэг татварын бус орлого	53,424,773.30	67,026,897.14
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		655,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	50,316,989.30	59,535,944.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	3,107,784.00	6,835,953.14
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,499,283,372.00	1,796,463,378.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,094,529,900.00	1,417,545,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,094,529,900.00	1,417,545,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	404,753,472.00	378,823,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	404,753,472.00	378,823,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		94,278.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		94,278.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,517,910,406.51	1,645,454,399.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,517,910,406.51	1,645,454,399.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,465,815,406.51	1,566,594,924.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	848,223,129.59	950,756,582.00
210101	Үндсэн цалин	610,346,538.59	667,650,087.50
210102	Нэмэгдэл	187,889,762.00	236,321,224.50
210104	Урамшуулал	49,986,829.00	46,785,270.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,492,256.08	119,003,775.26
210201	Тэтгэврийн даатгал	72,957,164.82	81,570,470.06
210202	Тэтгэмжийн даатгал	8,449,866.44	9,413,633.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,752,704.74	7,508,787.08
210204	Ажилгүйдлийн даатгал	1,658,298.98	1,817,329.53
210205	Эрүүл мэндийн даатгал	16,674,221.10	18,693,555.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	323,541,860.00	345,773,503.00
210301	Гэрэл, цахилгаан	17,128,141.00	21,101,457.55
210302	Түлш, халаалт	305,853,719.00	323,672,045.45
210303	Цэвэр, бохир ус	560,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,866,080.50	1,680,000.00
210401	Бичиг хэрэг	102,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	750,000.00	
210408	Бараа материал акталсны зардал	4,014,080.50	1,680,000.00
2105	Нормативт зардал	62,835,675.00	69,226,800.00
210502	Хоол, хүнс	62,835,675.00	69,226,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,200,000.00	3,800,000.00
210604	Урсгал засвар	14,200,000.00	3,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,830,400.00	3,604,954.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,775,800.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,054,600.00	3,604,954.63
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	96,826,005.34	72,749,309.14

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,805,906.00	21,305,330.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,423,600.00	10,386,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	64,596,499.34	41,057,679.14
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,095,000.00	78,859,475.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	52,095,000.00	49,609,278.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		94,278.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	52,095,000.00	49,515,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		29,250,197.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		29,250,197.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	34,797,738.79	218,035,876.11
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	40,415,954.90	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	40,415,954.90	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-40,415,954.90	
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-5,618,216.11	218,035,876.11

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,499,283,372.00	1,797,118,378.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		655,000.00
120	Нийтлэг татварын бус орлого		655,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		655,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,499,283,372.00	1,796,463,378.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,094,529,900.00	1,417,545,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,094,529,900.00	1,417,545,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	404,753,472.00	378,823,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	404,753,472.00	378,823,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		94,278.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		94,278.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,445,358,251.67	1,607,887,363.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,445,358,251.67	1,607,887,363.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,394,488,431.67	1,526,895,448.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	848,323,129.59	950,756,582.00
210101	Үндсэн цалин	610,446,538.59	667,650,087.50
210102	Нэмэгдэл	187,889,762.00	236,321,224.50
210104	Урамшуулал	49,986,829.00	46,785,270.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,352,982.08	119,016,379.04

210201	Тэтгэврийн даатгал	72,817,893.13	81,583,073.84
210202	Тэтгэмжийн даатгал	8,440,731.09	9,413,633.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,752,704.59	7,508,787.08
210204	Ажилгүйдлийн даатгал	1,667,431.39	1,817,329.53
210205	Эрүүл мэндийн даатгал	16,674,221.88	18,693,555.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	323,541,860.00	345,773,503.00
210301	Гэрэл, цахилгаан	20,996,060.00	21,063,360.00
210302	Түлш, халаалт	301,545,800.00	323,710,143.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	750,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	750,000.00	
2105	Нормативт зардал	57,996,054.00	65,392,500.00
210502	Хоол, хүнс	57,996,054.00	65,392,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,200,000.00	3,800,000.00
210604	Урсгал засвар	14,200,000.00	3,800,000.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,170,400.00	3,604,954.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,775,800.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,394,600.00	3,604,954.63
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,154,006.00	38,551,530.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,062,106.00	27,512,730.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,091,900.00	11,038,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,869,820.00	80,991,915.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,869,820.00	51,741,718.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		94,278.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	50,869,820.00	51,647,440.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		29,250,197.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		29,250,197.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	53,925,120.33	189,231,014.33
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		

IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	28,077,800.00	26,839,500.00
	Дотоод эх үүсвэрээр	28,077,800.00	26,839,500.00
222001	Тоног төхөөрөмж	28,077,800.00	26,839,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-28,077,800.00	-26,839,500.00
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	25,847,320.33	162,391,514.33
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		25,847,320.33
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		188,238,834.66

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	666,081,812.58	1,297,795,703.00	(478,939,793.91)	1,484,937,721.67
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Тайлант үеийн үр дүн				
10	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	666,081,812.58	1,297,795,703.00	(478,939,793.91)	1,484,937,721.67
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			218,035,876.11	218,035,876.11
19	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	666,081,812.58	1,297,795,703.00	(260,903,917.80)	1,702,973,597.78

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

ЗЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ	Үзүүлэлт	Тайлант оны	Зөрүү		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,820,310,600.00	1,634,726,863.67	185,583,736.33	89.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,820,310,600.00	1,607,887,363.67	212,423,236.33	88.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,761,512,100.00	1,526,895,448.67	234,616,651.33	86.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,106,380,800.00	950,756,582.00	155,624,218.00	85.93
210101	Үндсэн цалин	761,214,100.00	667,650,087.50	93,564,012.50	87.71
210102	Нэмэгдэл	288,098,100.00	236,321,224.50	51,776,875.50	82.03
210104	Урамшуулал	57,068,600.00	46,785,270.00	10,283,330.00	81.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	138,297,700.00	119,016,379.04	19,281,320.96	86.06
210201	Тэтгэврийн даатгал	94,042,400.00	81,583,073.84	12,459,326.16	86.75
210202	Тэтгэмжийн даатгал	11,063,800.00	9,413,633.33	1,650,166.67	85.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,851,000.00	7,508,787.08	1,342,212.92	84.84
210204	Ажилгүйдлийн даатгал	2,212,800.00	1,817,329.53	395,470.47	82.13
210205	Эрүүл мэндийн даатгал	22,127,700.00	18,693,555.26	3,434,144.74	84.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	375,023,700.00	345,773,503.00	29,250,197.00	92.2
210301	Гэрэл, цахилгаан	22,800,000.00	21,063,360.00	1,736,640.00	92.38
210302	Түлш, халаалт	351,223,700.00	323,710,143.00	27,513,557.00	92.17
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00		100
2104	Хангамж, бараа материалын зардал				
2105	Нормативт зардал	65,392,500.00	65,392,500.00		100
210502	Хоол, хүнс	65,392,500.00	65,392,500.00		100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,800,000.00	3,800,000.00		100
210604	Урсгал засвар	3,800,000.00	3,800,000.00		100
2107	Томилолт, зочны зардал				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,359,200.00	3,604,954.63	3,754,245.37	48.99
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,359,200.00	3,604,954.63	3,754,245.37	48.99
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,258,200.00	38,551,530.00	26,706,670.00	59.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,219,400.00	27,512,730.00	26,706,670.00	50.74
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,038,800.00	11,038,800.00		100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,798,500.00	80,991,915.00	(22,193,415.00)	137.7 4
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,798,500.00	51,741,718.00	7,056,782.00	88
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		94,278.00	(94,278.00)	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	58,798,500.00	51,647,440.00	7,151,060.00	87.84
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох		29,250,197.00	(29,250,197.00)	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		29,250,197.00	(29,250,197.00)	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		26,839,500.00	(26,839,500.00)	

	Дотоод эх үүсвэрээр		26,839,500.00	(26,839,500.000)	
222001	Тоног төхөөрөмж		26,839,500.00	(26,839,500.000)	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,822,202,800.00	1,797,118,378.00	25,084,422.00	98.62
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,417,545,400.00	1,417,545,400.00		100
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,417,545,400.00	1,417,545,400.00		100
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	378,823,700.00	378,823,700.00		100
132001	Орон нутгийн төсвөөс	378,823,700.00	378,823,700.00		100
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС				
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		94,278.00	-94,278.00	
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		94,278.00	-94,278.00	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	25,833,700.00	655,000.00	25,178,700.00	2.54
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	25,833,700.00		25,833,700.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		25,847,320.33	(25,847,320.33)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		188,238,834.66	(188,238,834.66)	
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	61	61		
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	61	61		

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Ерөнхий боловсролын лаборатори эрдмийн өргөө цогцолбор сургууль нь сургалтын үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Тайлант онд “Багш, суралцагч асран хамгаалагчийн хөгжлийг хамтын оролцоогоор дэмжин, сургалтын чанарыг ахиулсан хамт олон байх” гэсэн зорилгын хүрээнд дараахь зорилт дэвшүүлж ажиллажээ. Үүнд:

- Багшийн тасралтгүй хөгжлийг хангах, дэмжлэг үзүүлэх
- Суралцагчийн хөгжил төлөвшлийг дэмжсэн, эрүүл аюулгүй хамгаалагдсан орчин бүрдүүлэх
- Сурлагын амжилтыг ахиулж, чанарыг сайжруулах
- Эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн идэвх оролцоог нэмэгдүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус сургууль нь Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгал, Татварын багц хуулиуд, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2022 оны 107,192-р тогтоол, БШУС-ын 2022 оны А/500, А/494, А/430, А/122 дугаар тушаал, Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоол, "Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр, түүнийг хэрэглэх төрийн байгууллагуудын жагсаалт, орон тооны дээд хязгаар тогтоох тухай" 213 дугаар тогтоол, "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дугаар тогтоол, БШУС-ын 2023.06.13-ны өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 1а/2714 албан бичгээр ЕБС, цэцэрлэгийн нөхөн хангалтыг шийдвэрлэх талаар ирүүлсэн чиглэл зэрэг тайлант онд дээд шатны эрх бүхий байгууллагуудаас ирүүлсэн заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагыг хянан баталж дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг цахимаар хийж байна. Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ерөнхий боловсролын лаборатори эрдмийн өргөө цогцолбор сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 захирамжаар баталсан Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Энэ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ерөнхий боловсролын лаборатори эрдмийн өргөө цогцолбор сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг УСНББОУС, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тус сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 205,578.8 мянган төгрөгөөр буюу 9.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	13,482.6	140,490.4	127,007.8
Авлага	-		
Байгууллагаас авах авлага	-	-	-
Бараа материал	146,918.4	142,951.1	(3,967.3)
Үндсэн хөрөнгө	2,733,096.6	2,977,636.9	244,540.3
Үндсэн хөрөнгийн элэгдэл	(819,929.0)	(981,931.0)	(162,002.0)
Нийт хөрөнгө	<u>2,073,568.6</u>	<u>2,279,147.4</u>	<u>205,578.8</u>
Өр төлбөр	-	3,233.3	3,233.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,073,568.6	2,275,914.1	202,345.5
Өр төлбөр /богино хугацаат/			
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<u>2,073,568.6</u>	<u>2,279,147.4</u>	<u>205,578.8</u>

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам”-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 140,490.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Үүний 3,678.5 мянган төгрөг нь ахмадын сангийн хуримтлал байна. Цалин, НДШ-ийн зардлаас 155,624.2 мянган төгрөг зарцуулагдаагүй үлдсэн нь төсвийн төлөвлөлттэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,977,636.9 мянган төгрөг болж 244,540.3 мянган төгрөгөөр өсчээ. БШУС-ын 2023 оны А/230 дугаар тушаалаар хуваарилсан 51,548.6 мянган төгрөгийн нөхөн хангалтын зардлын санхүүжилтээр хөрөнгө худалдан авсан. БШУЯ-аас 181,958.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 38,554.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, 2,998.9 мянган төгрөгийн ном, 4,288.0 мянган төгрөгийн сурагчийн болон багшийн 2 ширхэг программ, аймгийн хөрөнгө оруулалтаар 8,130.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэлд тусгасан хөрөнгө шилжүүлэн авсан нь үндсэн хөрөнгө нэмэгдэхэд нөлөөлжээ.

Тайлант онд 56,071.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, 5,940.3 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлжээ.

Дотоод албан томилолтын 1,001.8 мянга, байгууллагад төлөх өглөг 2,231.5 мянган төгрөгийн өглөг шинээр үүсгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,275,914.1 мянган төгрөг болж 202,345.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 816,620.7 мянган төгрөгөөр буюу 27.0 хувиар өсөхөд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 212,378.8 мянга, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 662,811.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, нэмэлт санхүүжилтийн орлого 40,655.0 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Урсгал зардал өмнөх оноос 581,261.6 мянган төгрөгөөр өсчээ. Өмнөх оны үзүүлэлтээс цалин, хөлс болон нэмэгдэл урамшил 500,648.7 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 64,555.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Ерөнхий боловсролын лаборатори эрдмийн өргөө цогцолбор сургуулийн 2023 оны улсын төсвөөс санхүүжих төсвийг 2,034,201.0 мянган төгрөгөөр баталсныг тайлант онд 2 удаа өөрчлөлт оруулж зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 3,095,699.3 мянган төгрөгөөр буюу 1,061,456.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна. Энэ нь төсвийг үндэслэлтэй төлөвлөж, батлагдахгүй байгааг харуулж байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,417,545.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 378,823.7 мянган төгрөгийг төлөвлөжээ.

Төсөвт зардлын гүйцэтгэлийн тайланг хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэлээр тайлагнаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийг хангаагүй, УСНББОУС 1-д заасантай нийцэхгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрсөн орлого байхгүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ерөнхий боловсролын лаборатори эрдмийн өргөө цогцолбор сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн цаашид хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “ЦЭСБ аудит” ХХК-ийн аудитор Ш.Ганчимэг, аудиторын туслах Д.Туяа нар гүйцэтгэж, хяналтыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны санхүүгийн үр дүнгийн нийт зарлагын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,035,453.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 30,354.5 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын дүнгээс 70 хувиар тооцон 21,248.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус сургууль 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна. Хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлийн бусад арга хэмжээтэй холбоотой зардлыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

УСНББОУС бүртгэлийг бүрэн хэрэгжүүлээгүй, журнал хөтлөлтийг буруу бичилтээр хөтөлсөн 28,112.7 мянган төгрөгийн алдааг залруулах зөвлөмж хүргүүлж, жижүүрүүдэд шөнийн илүү цагийн нэмэгдлийг 2,879.9 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн 1 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1		1		100
Нийт дүн	1		1		100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

БЕГ-аас ирүүлсэн үүрэг чиглэлийн дагуу ер авлага үүсгэхгүй ажиллахад анхаарах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 20,778.2 мянган төгрөгийн алдааг залруулж, нийт 34,110.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 2,879.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 3,117.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 28,112.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Сургуулийн жижүүрүүдэд шөнийн цагаар ажилласан нэмэгдэл хөлсийг 2,879.9 мянган төгрөгөөр илүү тооцож, олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.2-т “Шөнийн цагаар ажилласан ажилтанг дараагийн ажлын өдөр шөнө ажилласан цагаас багагүй хугацаагаар нөхөн амраана”, 109 дүгээр зүйлийн 109.3-т “Шөнийн цагаар ажилласан ажилтанг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно.” гэж заасныг тус тус зөрчсөн тул төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Багш нарыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгооны жагсаалтад тусгагдаагүй шинжилгээнд хамруулж, 1,790.0 мянган төгрөг зарцуулсан нь БШУС, Эрүүл мэндийн сайдын 2022 оны хамтарсан А/328, 1/340 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг хамруулах” тухай журмын 1-д заасныг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлсэн.

2. Физикийн багш Б.Энхтайван, М.Үүрийнтуяа нарт сургуулийн бүтэц орон тоонд батлагдаагүй технологийн мэргэжилтэн албан тушаалд томилж, хавсран ажилласны нэмэгдэл хөлсөнд 1,327.6 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг тус тус зөрчсөн тул албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

1. Нягтлан бодох бүртгэлийн дансны бичилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

УСНББОУС бүртгэлийг бүрэн хэрэгжүүлээгүй, журнал хөтлөлтийг буруу бичилтээр хөтөлсөн 28,112.7 мянган төгрөгийн алдаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.3, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “НББ-ийн дансны заавар”, байгууллагын НББ-ийн бодлогын баримт бичигтэй нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид НББ-ийн дансны бичилтийг холбогдох стандарт, заавар журмын дагуу хөтлөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс					Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо	Залруулсан		Залруулаагүй			Тоо
					Тоо		Дүн	Дүн	Тоо	Дүн		
Акталсан бараа материалын зардлын дүнг 210408 дансанд тусгуулсан	1	20,778.2	1	20,778.2		1	20,778.2					
Дүн	1	20,778.2	1	20,778.2	-	1	20,778.2	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

